



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/56

Мандалговь

**“Нээлттэй мэдээллийн өдөрлөг”
зохион байгуулах тухай**

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг сонсох, салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг тайлбарлан таниулах зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр “Нээлттэй мэдээллийн өдөрлөг”-ийг зохион байгуулсугай.

2. “Нээлттэй мэдээллийн өдөрлөг”-ийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 3054800 (Гурван сая тавин дөрвөн мянга найман зуу) төгрөгийг нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Мөнхсаруул)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190113